

1

ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛЫН ТЭНХИМ: 50 ЖИЛ**Б.Сувд**

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхим нь Улс төрийн эдийн засгийн ухааны тэнхимээс үүсэлтэй.

1. МУИС-д Улс төрийн эдийн засгийн ухааныг 1944 оноос эхлэн заах болсон билээ. Анхны багш нь тэр үед улсын тоо, бүртгэл, хянан шалгах газрын ажилтан байсан Ж.Осор юм. Улс төрийн эдийн засгийн ухааны тэнхмийг анх 1947 онд нийгмийн ухааны факультетийн бүрэлдэхүүнд байгуулахад тэнхмийн эрхлэгчээр нь МАХН-ын төв Хорооны суртлын хэлтсийн зөвлөх В.А.Масленников хавсрлан ажиллаж байв.

1954 онд улс төрийн эдийн засгийн ухааны тэнхим бие даан байгуулагдсан түүхтэй. Эрхлэгч нь Зөвлөлтийн мэргэжилтэн Ленинградын улсын их сургуулийн багш, эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн Колосков байв. 1955 оноос эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн Галбадрах тэнхмийн эрхлэгчээр ажиллах болжээ.

1954 онд тус тэнхимд Ж.Осор, Ц.Гомбодорж, О.Цэнд, С.Зандан нар ажиллаж байлаа. 1959 оноос Эдийн засгийн факультетийг МУИС-Дас тусгаарлаж эдийн засгийн дээд сургууль байгуулахад энэ тэнхмийн эрхлэгчээр Б.Доржсүрэн, багш нар нь О.Цэнд, С.Зандан, Л.Занабазар, Г.Готов нар байжээ.

Тус тэнхмийн эрхлэгчээр 1960-1961 онд Ж.Батмөнх, 1961-1964 онд Г.Миеэгомбо, 1964-1965 онд Г.Готов, 1965-1968 онд С.Зандан, 1968-1974 онд Г.Миеэгомбо, 1974-1986 онд Г.Чалхаасүрэн, 1986-2002 онд Б.Сувд 2002 оноос Ц.Даваадорж нар ажиллаж ирлээ.

1961-1962 оны хичээлийн жилд, төгссөн Г.Чалхаасүрэн, Ү.Чимэд, Б.Намсрай, Жаргал, Д.Дорждэрэм, Д.Бордух, Дашиондог, Мэдэхгүй, Ц.Гомбодорж нарны жилийн курсээр бэлтгэж, УТЭЗҮ-ны багш болгосон нь багшлах боловсон хүчний өсөлтөд их ач холбогдолтой болсон байна. Энэ ажлыг Зөвлөлтийн мэргэжилтэн эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн Шакей Голумбексвич Надиров гардан гүйцэтгэсэн байна. Ихэвчлэн ЗХУ-д эдийн засагч УТЭЗҮ-ны багш, мэргэжлээр төгссөн хүмүүсийг тус тэнхим багшаар авч ажиллуулж байжээ.

МУИС-ийн улс төрийн эдийн засгийн ухааны тэнхим байгуулагдсан цагаасаа эхлэн оюутан запуучуудад Улс төрийн эдийн засгийн онолын үндэс эзэмшүүлэх, олон түмэнд түгээх, төрийн эдийн засгийн бодлогыг хөдөлмөрчдөд сурталчлах үргээ амжилттай биелүүлсээр иржээ. Тус тэнхимийн хамт олон

УТЭЗҮ-ны ном зохиол монголд нэвтрэн түгэхэд бодитой хувь нэмэр оруулж УТЭЗҮ-ны гол сурах бичгийн гурван удаагийн хэвлэлийг орос хэлнээс орчуулах ажлыг гүйцэтгэсний гадна олон тооны сурах бичиг, гарын авлага, зөвлөмж, арга зүйн материал, эрдэм шинжилгээний болон сурталчилгааны өгүүлэл хэвлэн нийтлүүлж радио телевиз лекц, яригаар хөдөлмөрчдөд сурталчилан хүргэж байв.

Тус тэнхим онолын судалгааны зэрэгцээ эрдэм шинжилгээний гэрээт ажил гүйцэтгэж 20 гаруй зөвлөмж, аргачлал боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн нь практик үр дүнгээ өгсөн. Мөн дээд боловсролын систем дэх УТЭЗҮ-ны хичээлийн сургалтыг онол, заах арга зүйн удирдлагаар хангадаг түшиц тэнхим байлаа.

Тэнхим Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн улс төрийн эдийн засгийн ухааны тэнхимтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, эрдэмтэдийг урьж ирүүлэн багш оюутнуудад лекц уншуулах, багш нараа явуулж мэргэжлийг нь дээшлүүлэх хамтын бүтээл туурвих эрдэм шинжилгээний онолын бага хурал хамтран зохион байгуулах зэргээр ажиллаж ирсэн уламжлалтай.

Энэ тэнхим жил бүр эдийн засгийн мэргэжлийн ангийн оюутнуудын дунд улс төрийн эдийн засгийн ухаан, эдийн засгийн онолын хичээлээр, олимпиад, эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл бэлтгүүлэн тодорхой сэдвээр эрдэм шинжилгээний ажилд дагалдуулан ажиллаж ирсэн байна. Ийнхүү тус тэнхим нь тухайн үеийн эдийн засагч боловсон хүчинийг бэлтгэн гаргахад эдийн засгийн онолын суурь үндсийг тавьж, УТЭЗҮ-ны чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх арга туршлагыг хуримтлуулсан тэргүүлэх тэнхим байсан нь энэ тэнхимд ажиллаж байсан үе үеийн шилдэг сэхэээтэн багшах боловсон хүчиний нэр их хөдөлмөрийн үр дүн гэдгийг бахархан тэмдэглэж байна.

2. Эдийн засгийн онолын тэнхимийн түүхэнд 1990 он бол шинэ үеийн эхлэлийг тавьсан билээ. Монгол улс дэлхий нийтийн жишигийн дагуу арчилал, зах зээлийн харилцаанд шилжих болсоноор их, дээд сургуулиудад заагдаж байсан хичээлүүдийн хөтөлбөрийг үндсээр нь өөрчлөх зах зээлийн эдийн засгийн онолыг заах, энэ онолын үндсэн дээр төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх чадвартай мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэн гаргах шаардлага зүй ёсоор тавигдсан юм.

Улс орон бүхэлдээ нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт хийж эхэлсэн энэ үед тус тэнхимийн хамт олон их дээд сургуульд заах Зах зээлийн эдийн засгийн онолын хичээлийн хөтөлбөрийг Монголд анх удаа боловсруулан гаргаж түүний дагуу хичээлээ зааж эхэлсэн нь тэнхимийн хөгжлийн хоёр дахь үеийн эхлэл болсон билээ. Эдийн засгийн онолын тэнхим нь Монгол улсад хийгдэж байсан шилжилтийн үеийн эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийн онолын үндсийг тайлбарлан таниулахын зэрэгцээ 1994 оноос эхлэн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд төрийн бодлого боловсруулж, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж,

хэрэгжүүлэх чадвар бүхий эдийн засгийн онолын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зорилгоор шинээр анги нээж мэргэжлийн сургалт явуулдаг болсоор эдүгээ б. удаагийн төгсөлтөө амжилттай хийгээд байна. Эдийн засгийн онолын сургалтыг дэлхийн жишигт ойртуулж оюутнуудын хичээлээр олж авсан онолын мэдлэгийг практикт хэрэглэх, эдийн засгийн үзэгдэл үйл явцыг эконометрикийн аргаар шинжлэн судлаж сурахад нь тус дэм болгох үүднээс 2001 онд Эдийн засгийн онолын тэнхмийн дэргэд эдийн засгийн онолын лабораторийг орчин үеийн иж бүрэн компьютер, бусад тоног төхөөрөмжтэйгээр хамт байгуулан ажиллаж байна. Тус лабораторт эконометрикийн орчин үеийн программууд дээр лабораторийн өгөгдлийн бааз болон интернетийн сүлжээг ашиглан эдийн засгийн онолын аль ч салбарын онолын болон эмпирик судалгаа шинжилгээг өндөр түвшинд хийх боломжтой.

Эдийн засгийн онолын тэнхмийн багш нараас олон хүн Япон, Австрали, Англи, АНУ, Австри, Солонгосын их сургуулиудад магистр, докторын зэргийг хамгаалсан ба одоо хамгаалахаар суралцаж байна.

Тэнхмийн багш нар сүүлийн 10 жилд зааж байгаа хичээлийнхээ чанар чансааг олон улсын стандартын түвшинд нийцүүлэн бакалавр, магистр, докторын сургалтыг явуулахын зэрэгцээ тэнхмийн эрдэм шинжилгээ- онол, заах арга зүйг сайжруулах, тэднийг судалгааны ажилд татан оролцуулах, нэг нөхцлийг бүрдүүлж өглөө. Одоо тус тэнхимээс 1993-1994 оны хичээлийн жилээс эхлэн тус тэнхимээс микро болон макро экономикс хичээлийг З түвшинд, хөгжлийн экономикс, эконометрикс, микро, макро эдийн засагт эконометрикийг хэрэглэх нь мөнгөний онол ба бодлого, эдийн засгийн сэтгэлгээний түүх, эдийн засгийн өсөлтийн онол болон олон улсын экономикс, менежментийн экономикс, байгаль орчны экономикс, нийгмийн сектор, хөдөө аж ахуйн экономикс, тоглоомын онол зэрэг хичээлүүдийг бакалаврын өдөр, орой, эчнээ ангиудын оюутнуудад, микро IV, макро IV, шилжилтийн экономикс, олон улсын экономикс, олон улсын мөнгөний онол, өсөлтийн онол, хөгжлийн эдийн засаг, олон улсын санхүү зэрэг хичээлүүдийг магиструудад зааж байна. Одоо тэнхимээс эдийн засгийн онолын мэргэжлийн ангиудад 29 төрлийн хичээл зааж байгаагийн ихэнх нь Монгол улсад шинээр заагдаж буй хичээлүүд юм.

Эдийн засгийн онолын мэргэжлээр төгсөгчид нь улс орны эдийн засагт гарч буй шинэчлэлт, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, эдийн засгийн бодлого боловсруулах, их, дээд сургуульд багшлах, судалгаа хийх аль нэг албан байгууллагын эдийн засгийн бодлогыг хариуцан ажиллах, шинээр байгуулагдах аж ахуйн нэгжүүдэд төсөл боловсруулж, зардал ашгийг нягтлан удирдаж зохион байгуулах бүрэн чадвартай мэргэжилтнүүд болон бэлтгэгддэг бөгөөд эдийн засгийн аль ч салбарт ажиллах чадварыг эзэмшдэг юм.


Одоо тус тэнхмийн багш нар Эдийн засгийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, СЭЗЯ, Дэлхийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны банкны захиалгаар ``Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал, шалгуур үзүүлэлт'', ``Монголын өрх гэрүүдийн эмзэг байдлын үнэлгээ'', ``Монгол дахь ядуурлын үнэлгээ'', ``Өмч хувьчлал ба ядуурал, тэгш бус байдал'', ``Эрүүл мэндийн салбарын хувьчлэл'', ``Үндэсний эдийн засгийн монгол номлол'' сэдэвт эрдэм шинжилгээний төсөлт ажлыг хариуцан гүйцэтгээд байна. Үүний зэрэгцээ эрдэм шинжилгээ сургалт судалгааны ажлын үр дүнгээр олон тооны бүтээл тууриован уншигч олны хүртээл болгоод байна.

Тус тэнхим нь олон улсын зуны сургалтыг Соросын сангийн дэмжлэгтэйгээр хоёр дахь удаагаа амжилттай зохион байгуулсан нь тэнхимиийн нэр хүнд олон улсын түвшинд өсөн бэхжихэд зүй ёсны хувь нэмэр болж байна.


ЭЗО-ын тэнхимиин хөгжлийн хоёр дахь үеийн онцлог бол эдийн засгийн онолын сургалт, судалгааг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн хөгжүүлэх их үйлст томоохон алхам хийж байгаа явдал юм. Энэ үеийн ололт амжилт бүхэн тус тэнхимиийн багш нарын үйл ажиллагаатай салшгүй холбоотой бөгөөд хэн юу хийж чаддагаа харуулах сайхан боломжийг залуучуудад олгож байгаад сэтгэл өөг байдгийг онцлон тэмдэглэж байна.

Тэнхмийнхээ 50 жилийн ойг тохируулан энэ тэнхимиийн халуун ам бүлд багтаж байдаг үе үеийн багш, ажилтан, эрдэмтэд та бүхэндээ баяр хүргэж аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн өрөө.

Тэнхмиийн багш нарын эрдмийн зэргийн байдал



Тэнхмээс гаргасан сурх бичиг, гарын авлага, төгсөгчид болон
гадаадад суралцагсад



Тэнхмийн багш нарын бүтэц

